



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

“Хатансүлд ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.3, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хатансүлд ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2013 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад сунгалтын талаарх тэмдэглэгээг 2013 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор хийлгэхийг “Хатансүлд ББСБ” ХХК /М.Монхор/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавин олон нийтэд мэдээлэж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ
ТОГТООЛ
353